



ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ТЕАТРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлуулах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Соёлын сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхэд, залуучуудын театрын дүрэм”-ийн 4 дэх хэсгийн 4.4.7 дахь заалт, “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.4.11, дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Ерөнхий нягтлан бодогч (Ж.Номин)-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Хүний нөөцийн төлөвлөлт, сургалт судалгааны мэргэжилтэн (Ц.Усанболороо)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (Ю.Батцэнгэл)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Н.АРИУНБОЛД

182492507